



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/337

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан "Тэрбум" мод үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилт элсний нүүдлээс хамгаалах зурвасын ажлын (12 га, Рашаант-3 га, Баяннуур-3 га, Гурванбулаг-3 га, Дашинчилэн-3 га) 1 дүгээр багц Баяннуур сумын "Цементийн хотос" сумын төвөөс зүйн хойд 1 км газарт 3 га талбай, Дашинчилэн сумын "Өлзийт" сумын төвөөс 3-5 км газарт 3 га талбайд улсын чанартай авто замын дагуу нийт 6 га талбайд ойн зурвасын ажлыг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Хөвөнтөн-ой" ХХК-тай 88,700,000 (Наян найман сая долоон зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгохыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д олгосугай.

2. Ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Хөвөнтөн-ой" ХХК-ийн захирал (Ч.Оюун)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА


Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010436

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 14 ны/ний өдрийн 1/337 дугаар
захирамжийн хавсралт



Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	А.Гантөмөр